



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2025 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 257

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хил хамгаалах ерөнхий газрын харьяа Хилийн цэргийн 0253 дугаар ангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 245,834,205.50 (хоёр зуун дөчин таван сая найман зуун гучин дөрвөн мянга хоёр зуун таван төгрөг тавин мөнгө) төгрөгийн балансын үнэ, 32,777,894.08 (гучин хоёр сая долоон зуун далан долоон мянга найман зуун ерэн дөрвөн төгрөг найман мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий Ниссан патрол маркийн 05-37 УБГ улсын дугаартай автомашиныг Улсын ерөнхий прокурорын газарт хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Хил хамгаалах ерөнхий газрын дарга, бригадын генерал Ж.Бямбасүрэн, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем”-д бүртгэх;

2.3.Автомашиныг автотээврийн улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132330860
11-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
 2025 оны дугаар сарын 1-ны өдрийн
 дугаар тогтоолын хавсралт



ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА ХИЛИЙН ЦЭРГИЙН 0253 ДУГААР АНГИЙН
 ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Автомашинны нэр, марк, улсын дугаар, арлын дугаар	Ашиглалтад орсон огноо	Ашиглах хугацаа	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Хүлээн авах байгууллагын нэр
1	Ниссан патрол 05-37 УБГ /Арал №GRJ1205082202/	11/21/2023	3.00	245,834,205.50	32,777,894.08	Улсын ерөнхий прокурорын газарт
				245,834,205.50	32,777,894.08	
Нийт дүн				(хоёр зуун дөчин таван сая найман зуун гучин дөрвөн мянга хоёр зуун таван төгрөг тавин мөнгө)	(гучин хоёр сая долоон зуун далан долоон мянга найман зуун ерэн дөрвөн төгрөг найман мөнгө)	